



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2009 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 155

Улаанбаатар хот

Г Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр, хамтын ажиллагааны хөтөлбөр болон Монгол улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол улсын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад төрийн буцалтгүй тусламж олгох журам"-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 4 дүгээр тушаалаар батлагдсан хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу 2009-2010 оны хичээлийн жилд ОХУ-аас Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэгээр суралцуулах оюутнуудын нэрсийн жагсаалтад Ринчинова Маринатай холбогдох хэсгийн "МУИС" гэсэн сургуулийн нэрийг "ЭМШУИС" гэж өөрчилсүгэй.

2. Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэгээр суралцагч Ринчинова Марина-д шаардагдах санхүүжилтийг хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр, хамтын ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол улсын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад төрийн буцалтгүй тусламж олгох журам", Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2008 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 451/318 дугаар хамтарсан тушаалын дагуу олгохыг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-д тус тус даалгасугай.

САЙД

Ё.ОТГОНБАЯР